



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

0000 оны 01 сарын 08 өдөр

Дугаар 102

Мандалговь

Г Ерөнхий боловсролын сургууль
болон сургуулийн өмнөх боловсролын
байгууллагуудын үйл ажиллагааг
түр хаах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "к", "л", Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.4, "Томуу, томуу төст өвчний харуулдан тандалтын тогтолцоог өргөжүүлэх тухай" Эрүүл мэндийн сайдын 2014 оны 358 дугаар тушаалын 3 дугаар хавсралтын 2.4.1 дэх заалт, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/05 тоот тушаал, аймгийн Онцгой комиссын 2020 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн 01 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

Нэг. Аймгийн хэмжээнд томуу, томуу төст өвчний тархалт ихэсч амбулаторийн нийт үзлэгийн 19.2 хувийг, яаралтай түргэн тусlamжийн шалтгаант дуудлагын 41.1 хувийг эзэлж байгаа тул өвчний тархалтыг бууруулах, халдвартал эрсдэлийг багасгах зорилгоор аймгийн хэмжээнд сургалт, хүмүүжлийн үйл ажиллагаа явуулж буй сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудыг 2020 оны 1 дүгээр сарын 8-ны өдрөөс, ерөнхий боловсролын сургуулийг 2020 оны 1 дүгээр сарын 13-ны өдрөөс эхлэн 2020 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр хүртэлх хугацаагаар хаасугай.

Хоёр. Дээрх хугацаанд аймгийн хэмжээнд хүүхдийн дунд зохион байгуулах нэгдсэн арга хэмжээ үйл ажиллагааг хязгаарлаж, тоглоомын газруудын үйл ажиллагааг хориглосугай.

Гурав. Томуу, томуу төст өвчнөөр өвчилсөн хүүхдээ эмнэлэг болон гэрээрээ асарсан ажил эрхэлж байгаа эцэг, эх асран хамгаалагчид 5 хүртэл хоногийн цалинтай чөлөөг холбогдох хууль, журмын дагуу олгож, өвчний тархалтын бууруулах, хүндрэлээс сэргийлэхэд дэмжлэг үзүүлж ажиллахыг сум, байгууллага, аж ахуй нэгжийн дарга, эрхлэгч наарт зөвшөөрсүгэй.

Дөрөв. Захирамжийг шуурхай хэрэгжүүлж, аймгийн Онцгой комиссыг томуу, томуу төст өвчний талаарх өдөр тутмын мэдээ мэдээллээр хангаж, шаардлагатай арга хэмжээг авч, хяналт тавьж ажиллахыг сумдын Засаг дарга нар, аймгийн Онцгой байдлын газар (М.Адъяабаатар), Эрүүл мэндийн газар (Г.Бат-Орших), Боловсрол, соёл, урлагийн газар (Ц.Бумангэрэл), Биеийн тамир, спортын газар (Д.Наранбадрах), Цагдаагийн газар (О.Амарсанаа), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ

Ж. МӨНХЧУЛУУН



482010004